




Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай (анхдагч)
хуулийн төсөл, үүнтэй уялдуулан боловсруулж ирүүлсэн
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөлд өгөх санал

Монгол Улсын Сангийн сайд З.Мэндсайханаас ирүүлсэн Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай (анхдагч) хуулийн төсөл, уг хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулж ирүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-д заасны дагуу Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэв.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай (анхдагч) хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, түүнийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагын талаар хэлэлцээд, эдгээр хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна.

1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд хөрөнгө оруулалтыг үнэлж эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа нь Засгийн газар, Сангийн яамны баталсан журмын хүрээнд хэрэгждэг бөгөөд нийгмийн чухал асуудлыг журмаар бус хуулиар зохицуулах бодлогын хүрээнд бие даасан хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай гэдгийг зарчмын хувьд дэмжиж байна.

Санал авахаар ирүүлсэн Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.5.4-т *“шүүх засаглал, хууль зүй, дотоод хэрэг, төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангахад чиглэсэн төрийн захиргааны салбарын төсөл”* нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төрөл байхаар тусгажээ. Гэхдээ шүүх эрх мэдлийн байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг зохицуулсан тодорхой зохицуулалт багтаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад эдийн засгийн баталгаа чухал ач холбогдолтой. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.3-т *“Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”* буюу Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийг Засгийн газар бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хуульчилсан.

Гэвч Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөлд шүүх эрх мэдлийн байгууллага нь Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шүүхийн төсвийн төслийг нэгтгэн өргөн барих боломжгүй, төсвийн өрөнхийлөн захирагч тус бүр төслийг үнэлж, эрэмбэлэн санхүү,

төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх¹, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт төслийг эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах санал боловсруулахаар² тусгагджээ. Энэ нь шүүх эрх мэдлийн эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг хангах эрх зүйн баталгааг сулруулж, Үндсэн хуульд нийцэхгүй үр дагавар үүсгэх эрсдэлтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т *“Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана”* гэж заасан бөгөөд төрөөс шүүхийн буюу иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эдийн засгийн баталгааг бүрэн хангах үүргийг Үндсэн хуулиар тогтоосон.

Иймд, Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль дахь шүүхийн эдийн засгийн бие даасан, хараат бус байдлыг хангах талаарх зохицуулалтад нийцүүлж, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.2.9-д *“санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 26.2.5-д заасны дагуу улсын төсвийн төсөлд тусгах санал боловсруулахдаа шүүхийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийг бууруулахгүйгээр тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”* хэсгийг нэмэх саналыг гаргаж байна.

2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд

2.1. Эрүүгийн хуулийн тусгай анги нь бүлэг, зүйл, хэсэг, заалтаас бүрдэх бөгөөд ихэвчлэн нэг зүйлд нэг гэмт хэргийн шинжийг тодорхойлж, тухайн гэмт хэргийн үндсэн буюу өрдийн бүрэлдэхүүн, хүндрүүлэх ба онцлон хүндрүүлэх шинж, оногдуулах ялын төрөл, хэмжээг хуульчлан тогтоодог.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай (анхдагч) хуулийн төсөл, уг хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулж ирүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгаснаар Эрүүгийн хуулийн 20.13 дугаар зүйлд 3, 4 дэх хэсэг нэмж, 3 дахь хэсэгт *“Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр чанар муутай барилга байгууламж барьсан, бариулсан, их засвар хийсэн, хийлгэсэн, чанар муутай тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, эсхүл энэ талаар шийдвэр гаргасны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан”* гэж,

мөн зүйлийн 4 дэх хэсэгт *“Энэ хуулийн 20.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон, ноцтой хохирол, хор уршиг учирсан”* гэж тус тус гэмт хэргийн шинжийг тодорхойлжээ.

¹ 26.2.4. төсвийн өрөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчаас ирүүлсэн төслийн саналыг нэгтгэж, салбарын болон улсын хөгжлийн бодлоготой уялдуулж, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох бөгөөд төслийг үнэлж, эрэмбэлэн, жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

² 26.2.5. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн өрөнхийлөн захирагчаас ирүүлсэн төслийн саналыг хөгжлийн бодлого, төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн эсэхийг хянаж, санхүүжилтийн болон төсвийн хязгаар, урсгал зардлын ачаалал зэргийг тооцсоны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт төслийг эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах санал боловсруулна;

Эрүүгийн хуулийн хорьдугаар бүлэгт Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргүүдийг тус бүрийн шинжээр хуульчилсны дотор мөн хуулийн 20.13 дугаар зүйлд “Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах” гэмт хэргийн шинжийг тусгайлан заасан.

Барилгын тухай хуулиар барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулж, нэгдсэн стандарт тогтоосноос үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр чанар муутай барилга байгууламж барьсан үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчлахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээтэй агуулгын хувьд давхцал, зөрчил, хийдэл үүсгэхгүй байхад анхаарч, Эрүүгийн хуулийн 20.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт оруулах байдлаар өөрчлөн найруулах боломжтой.

2.2.Мөн барилга байгууламж, тоног төхөөрөмж, барилга болон тоног төхөөрөмжид их засвар хийсэн гэх ойлголтууд нь ялгаатай байх бөгөөд чанар муутай барилга байгууламж барьсан, чанар муутай тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн, барилга болон тоног төхөөрөмжид чанар муутай их засвар хийсэн байдал нь өөр өөр үр дагавар үүсгэж байгаагаас хамааруулан тус бүрийн шинжээр ялгаатай авч үзэх нь зүйтэй.

2.3.Төсөлд Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр чанар муутай барилга байгууламж барьсан, бариулсан, их засвар хийсэн, хийлгэсэн, чанар муутай тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, эсхүл энэ талаар шийдвэр гаргасны улмаас ... гэж нөхцөл зааснаас үзэхэд нэг талд захиалагч, нөгөө талд гүйцэтгэгч байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай (анхдагч) хуулийн төслийн 4.1.5-д “гүйцэтгэгч” гэж захиалагчтай байгуулсан төсөл хэрэгжүүлэх гэрээний дагуу бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээг гүйцэтгэх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.8-д “захиалагч” гэж энэ хуулийн 17.1-д заасан этгээдийг гэж тодорхойлоод 17.1.1-д төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төсвийн захирагч;

17.1.2-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлд³ заасан этгээд нь захиалагч гэж тус тус тодорхойлжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай (анхдагч) хуулийн төслийн 4.1.8-д заасан “захиалагч”-д хамаарах субъектийн албан үүрэг, бүрэн эрх, эрх мэдэлтэй нь уялдуулан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу Авлигын гэмт хэрэгт тусгайлан хуульчлах нь үр нөлөөтэй зохицуулалт болно гэж үзэж байна.

³ 45.1.Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

2.4.Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт нэмж 22.14 дүгээр зүйл (Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон өмч хөрөнгийг муутгах, ашиглах боломжгүй болгох) оруулахаар төсөлд тусгажээ.

Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, сайжруулалт, хадгалалт, хамгаалалтыг зохих ёсоор хийгээгүйгээс чанар байдлыг хэвийн хэмжээнээс илүүгээр муутгасан, ашиглах боломжгүй болгосон, их засвар хийх шаардлагатай болсон, төсөвт их хэмжээний хохирол учирсан гэж тухайн гэмт хэргийг тодорхойлсон боловч тухайн гэмт хэргийн субъект тодорхой биш байх тул албан тушаалтны албан үүрэг, бүрэн эрх, эрх мэдэлтэй нь уялдуулан субъектийг заах шаардлагатай.

2.5.Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.1.33-д "инженерийн дэд бүтэц" гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг гэж нэр томъёоны тайлбар хийжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дээрх инженерийн дэд бүтцэд хамаарах байгууламжтай холбоотой асуудлыг Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэгт тооцох эсэхийг анхаарвал зохино.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН